



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/397

Мөрөн сум

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2019 оны "Түрээсийн орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай" 223 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын XIV хуралдааны 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн "Орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай" 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлсэн "Шинэ мөрөн" хорооллын 135 айлын орон сууцны барилгыг түрээслэхээр сонгогдсон иргэд, Монгол Улсын Хөгжлийн банкны төлөөллийн уулзалтын үйл ажиллагааг зохион байгуулах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, холбогдох арга хэмжээг авах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батбилгүүн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: Б.Должинсорогдог (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Болд (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах албаны дарга)

Б.Билэгт-Отгон (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны Бодлого төлөвлөлт, Хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Ш.Дамдиндорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Далайжаргал (Шинэ мөрөн" хороолол 135 айлын орон сууц хариуцсан ажилтан)

2. Монгол Улсын Хөгжлийн банкны удирдлагын төлөөлөл Шинэ Мөрөн 135 айлын оршин суугчидтай уулзалт хийж, холбогдох арга хэмжээг авч танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

3. Дээрх үйл ажиллагаатай холбогдуулан Түрээсийн орон сууц хариуцсан ажилтны хөдөлмөрийн гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/154 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ